



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/353

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.15, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөө"-ний 1.1.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мандалговь хот Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёонги мужийн Галын академиас зохион байгуулах "Олон Улсын гал сөнөөгч, аврагчдын сургалт"- д хамрагдах алба хаагчдын зардал (ирэх буцах унаа)-д шаардагдах 3000000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Замын зардалд шаардагдах 3000000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191005